

Төсөл

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, МУЗЕЙГ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЗЭРЭГЛЭЛД ХАМААРУУЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Дээд боловсролын сургалтын байгууллагыг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлт:

№	Үнэлгээний үзүүлэлтийн нэр	Босго үзүүлэлт
1	Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж байгаа багш нарын хувь	70-аас доошгүй
2	Нийт багш нарын дотор доктор, шинжлэх ухааны докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувь	50-аас доошгүй
3	Нийт суралцагчдын дотор магистрант, докторантын эзлэх хувь	30-аас доошгүй
4	Магистрант, докторантын дотор эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэгчийн эзлэх хувь	50-аас доошгүй
5	Нийт орлогод судалгаа хөгжүүлэлтийн ажлын орлогын эзлэх хувь	20-оос доошгүй
6	Нийт судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотор технологи хөгжүүлэлтийн чиглэлээр гүйцэтгэсэн ажлын эзлэх хувь	30-аас доошгүй
7	Шинжлэх ухааны холбогдох чиглэлээр судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх эрдэм шинжилгээний лабораторийн хангамж	Шинжлэх ухааны холбогдох чиглэл бүрээр төрөлжсөн лабораторитой байх
8	Нийт номын фондод дотоод, гадаадын эрдэм шинжилгээний бичиг, сэтгүүл, нэг сэдэвт бүтээлийн эзлэх хувь	25-аас доошгүй
9	Эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний бүтээл, сэтгүүл	Шинжлэх ухааны холбогдох чиглэл бүрээр
10	Туурвисан нийт эрдэм шинжилгээний бүтээлд олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэл болон патент авсан бүтээлийн эзлэх хувь	10-аас доошгүй
11	Сүүлийн 3 жилд боловсруулсан эрдэм шинжилгээний бүтээлийн дотор үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтэрч ашиглагдсан бүтээлийн эзлэх хувь	30-аас доошгүй
12	Эрдэмтэн, багш нарын эрдэм шинжилгээний хурал, семинар	Тусгай хөтөлбөрөөр тогтмол зохион байгуулдаг байх
13	Нэг багшид ноогдох эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулж буй зардал (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлэн тооцсон)	x6
14	Нэг багшид ногдох эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажлын орлого (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлэн тооцсон)	x4

Төсөл

Хоёр. Музейг эрдэм шинжилгээний байгууллын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлт:

№	Үнэлгээний үзүүлэлтийн нэр	Босго үзүүлэлт
1	Музейн сан хөмрөгийг иж бүрдүүлэх, үзмэрт түшиглэсэн судалгаа явуулах, баяжуулах, сэргээн засварлах, ашиглах, хадгалж хамгаалах, нийтийн хүртээл болгох, тэдгээрийн гарал үүсэл, үнэ цэнийг тогтоох чиглэлээр дангаараа буюу эрдэм шинжилгээний холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх судалгаа хөгжүүлэлтийн ажил	3-с доошгүй судалгаа хөгжүүлэлтийн ажлыг тогтмол гүйцэтгэдэг байх
2	Үзмэрийн тодорхойлолтын бүрдэл	Үзмэрийн сан хөмрөгийн 60-аас доошгүй хувьд нь шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг, мэдээлэл бий болгосон байх
3	Нийт ажиллагчдын дотор эрдэм шинжилгээний ажилтан (судалгааны ажилтан)-ы эзлэх хувь	10-аас доошгүй
4	Судалгааны ажилтны дотор магистр, доктор, шинжлэх ухааны докторын зэрэгтэй ажилтны эзлэх хувь	30-аас доошгүй
5	Эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүл, судалгааны ном, товхимол, гарын авлага	2-оос доошгүй нэр төрөл
6	Тухайн музейн жилийн төсөвт эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн зардлын эзлэх хувь	10-аас доошгүй
7	Эрдмийн зөвлөл	Зөвлөлтэй байх